



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/396

Зуунмод

┌ Шагналын жишиг хэмжээ тогтоох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, Эрүүл мэндийн Сайдын 2017 оны А/472 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хамт олон, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэн, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэн ажиллаж, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, “Эрүүл ажлын байр”-ны шалгуур, болзлыг хангасан байгууллагад олгох шагналын жишиг хэмжээг хавсралтаар тогтоосугай.

2.Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын болзолд ирүүлсэн албан байгууллагын материалыг жилд 1 удаа комиссын хурлаар хэлэлцүүлэн, жишиг дүнг харгалзан урамшуулж ажиллахыг Засаг даргын орлогч /Ч.Сарангэрэл/-д үүрэг болгосугай.

3.“Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, “Эрүүл ажлын байр”-ыг орон нутгийн түвшинд шалгаруулахад шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн төсөвт тусган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ю.Бямбацогт/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын
2019 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
А/396 дугаар захирамжийн хавсралт

**“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА”, “ЭРҮҮЛ АЖЛЫН
БАЙР”-ААР ШАЛГАРСАН БАЙГУУЛЛАГА, ХАМТ ОЛОНД ОЛГОХ ШАГНАЛЫН
ЖИШИГ ХЭМЖЭЭ**

№	Орон нутгийн зэрэглэл	Шалгаруулах байгууллагын тоо	Дагалдах мөнгөн шагнал
Нэг. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага			
1	1 дүгээр зэрэг /90.0-100 оноо/	2	300,000
2	2 дугаар зэрэг /75.0-89.9 оноо/	2	200,000
3	3 дугаар зэрэг /60.0-74.9 оноо/	3	100,000
Хоёр. Эрүүл ажлын байр			
1	1 дүгээр зэрэг /90.0-100 оноо/	1	200,000
2	2 дугаар зэрэг /75.0-89.9 оноо/	2	150,000
3	3 дугаар зэрэг /60.0-74.9 оноо/	2	100,000

---oOo---